

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК

Эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 2/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

<i>Тайлагнах хугацаа</i>	2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 30 өдөр		
<i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</i>	“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК УБГД:000267784 Хувийн хэргийн дугаар:9012001021 ҮЦКод:510 Утасны дугаар : 11-313747		
<i>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</i>	“Монголын Хөрөнгийн Бирж” ХК		
<i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i>	66110-Үнэт цаасны зах зээлд үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа болон өөрийгөө зохицуулах байгууллага		
<i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</i>	350,463,539 ширхэг		
<i>Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</i>	Бэлтгэсэн: Т.Баасанцэнд, тооцооны нягтлан бодогч, С.Ариунсанаа, бизнес хөгжил хариуцсан ахлах мэргэжилтэн Хянасан: Х.Эрдэнэбүрэн, Захиргаа, санхүүгийн газрын захирал/		
1.	<i>Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i>		
<i>Санхүүгийн байдлын</i>	Үзүүлэлт	1/1/2023	06/30/2023
	ХӨРӨНГӨ		
	Эргэлтийн хөрөнгө	2,296,778,319.65	75,368,457,457.00
	Эргэлтийн бус хөрөнгө	23,184,922,418.26	22,731,427,454.07
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	25,481,700,737.91	98,099,884,911.07
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
	Богино хугацаат өр төлбөр	998,657,547.96	59,611,617,217.80
	Урт хугацаат өр төлбөр	990,846,139.66	942,328,068.79
	Эздийн өмчийн дүн	23,492,197,050.28	37,545,939,624.48
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	25,481,700,737.91	98,099,884,911.07	
<i>Орлогын тайлан Үзүүлэлт</i>	Үзүүлэлт	1/1/2023	06/30/2023
	Борлуулалтын орлого (цэвэр)	4,241,344,850.62	5,008,723,222.36
	Борлуулалтын өртөг		
	Нийт ашиг (алдагдал)	4,241,344,850.62	5,008,723,222.36
	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	769,747,808.21	2,369,115,243.63
	Орлогын татварын зардал	123,519,584.56	279,651,040.30
	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	646,228,223.65	2,089,464,203.33
	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	20,008,784,115.62	
	Орлогын нийт дүн	20,655,012,339.27	2,089,464,203.33

		Үзүүлэлт	1/1/2023	06/30/2023
Өмчийн өөрчлөлтийн тайлан		Өмч	23,130,593,600.00	35,046,353,900.00
		Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	20,021,146,332.29	20,069,664,403.16
		Эздийн өмчийн бусад хэсэг	446,321,902.02	446,321,902.02
		Хуримтлагдсан ашиг	(20,105,864,784.03)	(18,016,400,580.70)
		Нийт эздийн өмчийн дүн	23,492,197,050.29	37,545,939,624.48
Мөнгөн гүйлгээний тайлан		Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(705,389,180.92)	61,994,334,712.82
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(423,392,511.67)	190,379,595.00
		Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	131,127,879.87	11,915,759,800
		Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(997,653,812.73)	72,709,077,716.07
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,729,363,635.92	1,731,709,823.19
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,731,709,823.19	74,440,787,539.26
2.	<i>Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</i>			
3.	<i>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</i>			
3.1.	<i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>	Нийт ашгийн хувь 47% Эздийн өмчийн өгөөж/ ROE/ 6% Нийт хөрөнгийн өгөөж /ROA/ 2.1%		
3.2.	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i>	Эргэлтийн харьцаа 1.26 Түргэн хөрвөх чадварын харьцаа 1.26 Өр болон өөрийн хөрөнгийн <i>харьцаа</i> 1.6		
3.3.	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</i>	<p>МХБ нь Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 12-р сарын 14-ний өдрийн 466 дугаар тогтоолоор батлагдсан “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”-ын хэрэгжилтийг хангаж, 2023 оны 1 дүгээр сараас comex.mse.mn систем, дэд бүтцийг хөгжүүлж, арилжааг амжилттай зохион байгуулж эхэлсэн.</p> <p>Энэ хугацаанд “Эрдэнэс тавантолгой” ХК, Тавантолгой ХК, “Хангад эксплорэйшн” ХХК, “Энержи ресурс” ХХК зэрэг 4 компанийн экспортод гаргах 5 төрлийн (Баяжуулсан коксжих нүүрс, Баяжуулсан сул коксжих нүүрс, 1/3 коксжих нүүрс, Эрчим хүчний нүүрс, Дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрс) нийт 3.1 сая тонн нүүрсийг арилжаалсан бөгөөд МХБ-ийн арилжааны системд 176 компани худалдан авах санал гаргагчаар бүртгүүлж, арилжаанд зуучлагчгүйгээр шууд оролцож байна.</p> <p>Түүнчлэн, 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс мөрдөгдөж эхлэх “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлын хүрээнд Монголын хөрөнгийн бирж тус хуульд заасан 11 харилцааг зохицуулах нэр бүхий дараах таван журмыг боловсруулж, Санхүүгийн зохицуулах хорооноос уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авлаа.</p>		

		<ul style="list-style-type: none"> • “Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, төлбөр тооцоог гүйцэтгэхэд баримтлах журам”, • “Биржийн зах зээлийн зарим оролцогчийг итгэмжлэх, тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулах журам” • “Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журам”, • “Нүүрсний арилжааны гэрээний стандартыг тогтоох, мөрдүүлэх журам”, • “Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны хяналт шалгалтын журам” <p>2023 оны эхний хагас жилд системийн нөлөө бүхий 3 арилжааны банкны IPO, 2 компанийн IPO, 2 ХБҮЦ, 3 компанийн бондын анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгууллаа.</p> <p>Компанийн гадаад харилцаа өргөжин тэлж 2023 оны 05 сард Будапештийн хөрөнгийн биржтэй, 06 сард Шанхайн хөрөнгийн биржтэй тус тус хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа.</p> <p>Зах зээлийн нийт үнэлгээ нийт 10.99 их наяд төгрөгт хүрч оны эхэнтэй харьцуулахад 4.1 их наядар буюу 59.52%-иар өссөн нь 2022 оны ДНБ-ийн 20 хувьтай тэнцэж байна.</p> <p>Цаашид 2023 оны бизнес төлөвлөгөөний дагуу үнэт цаасны зах зээлд болон уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлд арилжигдаж буй бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, арилжааг идэвхжүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллана.</p>
3.4.	<p><i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/</i></p>	<p>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй .</p>
4.	<p><i>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</i></p>	
5.	<p><i>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</i></p>	

ТУЗ-ийн үүрэг

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь МХБ-ийн үйл ажиллагааны үр дүнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээдэг.

ТУЗ гүйцэтгэх захирлын ажлын үр дүнг үнэлэх, дүгнэх, томилох, дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах зэрэг үүрэгтэй. МУ-ын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 тоот тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”, УИХ-ын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 244 дүгээр тогтоолуудын дагуу “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь нийт хувьцааны 34 хүртэл хувьтай тэнцэх нэмэлт хувьцааг гаргаж, биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгон худалдахаар болсонтой холбогдуулан дараагийн дунд хугацааны төлөвлөлт буюу 2023-2027 онд хэрэгжүүлэх стратегийг тодорхойлж, түүний хэрэгжилтэд хяналт тавьж, удирдамж, зөвлөмжөөр хангаж ажиллалаа. Тайлант хугацаанд МХБ-ийн гүйцэтгэх удирдлагын баг үйл ажиллагааны стратеги, зорилго, зорилгоо хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих зорилгоор тогтмол хуралдсан байна. ТУЗ-ийн үүргийг “Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн дүрэм” болон “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-д тодорхой заасан байдаг.

ТУЗ-ийн хороод

МХБ нь ТУЗ-өөс даалгасан тодорхой үүрэг хариуцлага бүхий байнгын 3 хороотой ба эдгээр хороод нь ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг болох зорилгоор санал дүгнэлт гаргах үндсэн зорилготой. Хороодын үйл ажиллагааг “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”- аар зохицуулдаг.

ТУЗ нь дараах байнгын хороодтой:

- Нэр дэвшүүлэх хороо;
- Аудитын хороо;
- Цалин, урамшууллын хороо.

ТУЗ-ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болно. Компанийн тухай хуульд ТУЗ-ийн хараат бус гишүүн нь аудитын хороонд ажиллахаар заасан байдаг.

ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, шинэчлэх

ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүнийг бүрдүүлэхэд хараат бус үнэлгээ дүгнэлт гаргах зорилгоор нэр дэвшүүлэх хороог байгуулдаг. Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүдийн ур чадвар, туршлагыг хянан шалгаж, гишүүдийн ур чадвар МХБ-ийн үйл ажиллагааны стратегийг тодорхойлох, түүний хэрэгжилтэд хяналт тавих зэрэг үйл ажиллагааг хангаж ажиллахад зохистой эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгдөг. Энэхүү үнэлэлт, дүгнэлтэд үндэслэн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд шинээр оруулах гишүүнийг нэр дэвшүүлдэг. Гишүүдийг томилохоос өмнө Компанийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм журмын дагуу боловсрол, ур чадвар, өмнөх ажил эрхлэлтийн түүх, их хэмжээний зээлийн өртэй эсэх, гэмт хэрэгт холбогдсон эсэх зэрэг асуудлаар цогц судалгаа, шинжилгээг мөн хийдэг.

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 14 тоот тогтоолын дагуу МХБ-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зохион байгуулж энэхүү хурлаар МХБ-ийн ТУЗ-ийн гишүүд болон хяналтын зөвлөлийн гишүүд сонгогдсон.

ТУЗ-ийн дарга:

- Д.Тогтохбаяр /МУБИС-ийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга/

ТУЗ-ийн ердийн гишүүд: С.Баянцогт /“Алтайн зам” ХК-ийн Санхүүгийн хэлтсийн захирал/

- Ж.Бямбасүрэн /ЗГХЭГ-ын Санхүү, эдийн засгийн газрын дарга/
- Т.Ганбаатар /УУХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга/
- Ж.Цогтбаяр /Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Санхүүгийн хяналт шалгалтын хэлтсийн дарга/

ТУЗ-ийн хараат бус гишүүд:

- М.Банзрагч /ШУТИС-ийн Бизнесийн ахисан түвшний сургуулийн Сургалт, чанарын албаны дарга/
- Р.Мөнхтөр /“Эс Ай Би Жэй” капитал ХХК-ийн Дэд захирал/
- Н.Отгончимэг /“Сүлд-Аудит” ХХК-ийн Аудитор/
- Н.Улаанхүү /“АйСиТи групп” ХК-ийн Хөрөнгө оруулалт хариуцсан захирал/

Хяналтын зөвлөлийн гишүүд:

- Д.Батбаяр /Ди Си Эф ҮЦК ХХК-ийн Гүйцэтгэх захирал/
- Б.Туяарах /“Эрдэнэс Ассет Менежмент ҮЦК”-ийн Гүйцэтгэх захирал/
- Ц.Мөнхзул /Монгол Германы хамтарсан ашигт малтмал технологийн их сургуулийн Ахлах хуулийн зөвлөх/

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга:

ТУЗ үйл ажиллагаагаа хэвийн явуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах зорилгоор ТУЗ-д шууд хариуцлага хүлээх нарийн бичгийн даргыг томилох үүрэгтэй. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар компанийн ахлах хуульч Г.Тэмүүжин хавсран ажиллаж байна.

б. *Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой мэдээлэл*

-

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Х.Алтай

Албан тушаал: "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)



Мэдээлэл бэлтгэж хургуулсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Х.Эрдэнэбүрэн

Албан тушаал: Захиргаа, санхүүгийн газрын захирал

Гарын үсэг: